

Сурагчийн нэр:

4.2ж. Ойсон гэрлийн тусламжтай биеийг хардаг болохыг зурж харуулах

1. Хэрэглэгдэхүүнээ бэлтгэж, туршилт гүйцэтгэсэн эсэхээ тэмдэглээрэй.**Туршилт****Хэрэглэгдэхүүн:** гэрэл үүсгэгч, гэрэл нэвтэрдэггүй аяга, биет, хатуу цаас**Туршилт хийх дараалал:**

1. Аяганд биетийг хийгээд цаасаар таглана.
2. Таглааг аажмаар нээгээд биет харагдаж буй эсэхийг тайлбарлана.
3. Ажлын хуудсанд биетийг харсан чиглэлийг цацрагаар зурж тэмдэглэнэ.

2. Туршилт гүйцэтгэсэн явцаа эргэцүүлэн асуултад хариулж, сонгоорой.

- Аягыг хатуу цаасаар тагласан үед доторх зүйлийг харж чадсан уу?

Тийм

Үгүй

Яагаад? _____

- Аяган доторх зүйлийг харахад юу тусалсан бэ?

Таглаа

Аяга

Гэрэл

3. Туршилтын үр дүнг зурж тэмдэглээрэй.*Гэрлийн цацрагийг сумаар тэмдэглэе. Сумыг зөөж байршуулан, аяганд байсан зүйлийг хэрхэн харсан чиглэлийг зөв тодорхойлоорой.***Дүгнэлт. Зөв дүгнэлт гаргах өгүүлбэрийг сонгоорой.**

- А. Гэрэл үүсгэгч болон нүднээс гарах гэрлийн тусламжтайгаар хүн хардаг.
- Б. Биет дээр туссан гэрэл ойж, ойсон гэрлийн тусламжтайгаар хүн хардаг.
- В. Гэрэл үүсгэгчээс гарсан гэрэл биет болон нүд рүү тусч байгаа учраас хүн хардаг.

Даалгавар тус бүрийг гүйцэтгэсэн эсэхийг тэмдэглээрэй.  Өөрийн үнэлгээ: